

НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН
ДЭРГЭДЭХ ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

№

2023 оны 01 сарын 09

Налайх дүүрэг

Налайхын Барилгын Материалын Үйлдвэрлэл, Технологийн Паркийн дэргэдэх Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлыг газрын даргын өрөөнд 2023 оны 01 сарын 09-ны өдрийн 11:00 цагт эхлэж, 11:30 минутад дуусгав.

Хуралд: Зөвлөлийн дарга
Нарийн бичгийн дарга
Гишүүд:

Н.Пүрэвсүрэн
Э.Энгүүн
Г.Ганцэцэг
Б.Батбилэг нар оролцов.

ХЭЛЭЛЦСЭН НЬ: 1. 2022 оны жилийн эцсийн тооллогын ажлын тайлантай танилцах, дүгнэлт гаргах

СОНССОН НЬ: Н.Пүрэвсүрэн: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Бүгд 2022 оны жилийн эцсийн тооллогын тайлантай танилцсан. Энэ удаагийн тооллогоор актлах хөрөнгө байхгүй. Харин нэршлийн зөрүүтэй 3 эд хөрөнгө, техник ашиглалтын паспорт хариуцагчийн тэмдэглэлтэй холбоотой 1 зөрчил гарсан байна.

Б.Батбилэг: Няравын ажилтай холбоотой зөрчлүүд байх шиг байна аа. Иймд хариуцсан ажилтнаар гарсан зөрчлийг арилгуулах нь зөв байх.


Н.Пүрэвсүрэн: Дээрх яригдсан зөрчлийг арилгах 1 сарын хугацаатай үүрэг даалгаврыг байгууллагын нярав Э.Ундармаад өгье.

Г.Ганцэцэг: Дэмжиж байна.

Э.Энгүүн: Дэмжиж байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: 2022 оны жилийн эцсийн тооллогоор гарсан 4 төрлийн зөрчлийг арилгах үүрэг даалгаврыг нярав Э.Ундармаад өгөх.

ХЯНАСАН:
КОМИССЫН ДАРГА
ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Н.ПҮРЭВСҮРЭН
Э.ЭНГҮҮН